

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2024 ОНЫ 3 ДУГААР УЛИРАЛД БҮРТГЭЛ ХЯНАЛТАД АВСАН ЗАХИРАМЖИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН

2024 оны 12 дугаар сарын 15

Мандалговь хот

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Аймгийн Засаг даргын 2024 оны 4 дугаар улиралд батлан гаргасан захирамжийн хэрэгжилтийн үр дүнг үнэлэх, зөвлөмж гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, захирамжийн хэрэгжилтийн үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулахад хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

ХОЁР.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Аймгийн Засаг даргын 2024 оны 4 дүгээр улиралд батлан гаргасан хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.3-т заасан аргачлалаар хийлээ.

Аймгийн Засаг даргаас 2024 оны 4 дүгээр улиралд батлан гаргасан үүрэг болгосон үр дүнг эргэн тооцох 19 захирамжийн 19 заалтын хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Төрийн захиргааны, удирдлагын хэлтэс холбогдох сум, хэлтэс, агентлагуудаас биелэлтийг гаргуулан авч нэгтгэн тайланг 2024 оны 12 дугаар сарын 09-ний өдөр эцсийн байдлаар ирүүлсэн.

ГУРАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН


Аймгийн Засаг даргын 2024 оны 4 дүгээр улиралд хяналтад авсан 19 захирамжийн 19 заалт 82,1 хувийн хэрэгжилттэй байна. Үүнээс 100 хувь -13, 70 хувь -2, 30 хувь-4 заалт байна.

Дүнгээс харахад: Бүрэн хэрэгжсэн буюу 100 хувьтай 13 заалт нь нийт заалтын 68 хувийг, хэрэгжих шатандаа буюу 70 хувьтай хэрэгжиж байгаа 2 заалт нь 10 хувийг, 30 хувьтай 4 заалт нь 21 хувийг тус тус эзэлсэн байна.


Явцын дүнг хүснэгтээр харуулбал:

Д/ Д	Шийдвэрийн нэр	Заалтын тоо	Хэрэгжилтийн хувь			Хэрэгжилтийн дундаж хувь
			100	70	30	
1	Аймгийн Засаг даргын 2 дугаар улирлын захирамж	19	13	2	4	82,1

Захирамжийн тоо болон хэрэгжилтийн хувийг графикаар харуулбал:



Захирамжийн тоо болон хэрэгжилтийг хувийг өмнөх улиралтай харьцуулбал:




ОНЦЛОХ АРГА ХЭМЖЭЭНҮҮДЭЭС ДУРДВАЛ:

1. Аймгийн Засаг даргын А/654 дугаар захирамжаар энгийн механик аргаар бэлчээрийн хортон мэрэгч үлийн цагаан оготнотой Адаацаг, Дэлгэрцогт, Дэрэн, Эрдэнэдалай 4 суманд 40,0 мянган га бэлчээрийн талбайд тэмцэх ажлыг тус тус зохион байгуулж дээрх сумдад шувууны үүр 100 ш, утагч багаж 8 ш, үлий цөмлөгч 8 ширхгийг хуваарилан олгосон. Нийтдээ 60 мянган га бэлчээрийн талбайд хортон мэрэгчтэй тэмцэх ажлыг гүйцэтгэсэн. Хээрийн техникийн үр дүн 82,7% хувьтай хангалттай сайн ажилласан. УТ-176,3 төгрөг.



2. 2025 оны төсвийн төслийг хууль журамд нийцүүлэн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж аймгийн ИТХ-д хуулийн хугацаанд өргөн мэдүүлсэн байна.



3. Аймгийн Засаг даргын 2024 оны 11 сарын 01-ний өдрийн А/787 дугаар захирамжаар “Бүх нийтийн их цэвэрлэгээг” зохион байгууллаа. Бүх нийтийн цэвэрлэгээнд 50 төрийн байгууллага, 95 аж ахуйн нэгжийн 603 төрийн албан хаагч, иргэд оролцож 315 тонн хог хаягдлыг цэвэрлэж, нэгдсэн хогийн цэгт хаясан.



4. Аймгийн Засаг даргын 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/817 дугаар захирамжаар батлагдсан ажлын хэсэг агро ойн аж ахуй байгуулсан ажлыг 97 хувьтай хүлээн авсан. Улсын төсвийн 429 сая төгрөгөөр гүйцэтгэсэн.



ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Аймгийн Засаг даргын баталсан захирамжийн хэрэгжилтийн явцад улирал бүр хяналт шинжилгээ, үнэлгээг хийж үр дүнг тооцон ажиллаж байна.

4 дугаар улирлын захирамжийн хэрэгжилтийн дундаж 82,1 хувьтай хэрэгжиж өмнөх улиралтай харьцуулахад 5 заалтаар нэмэгдэж хэрэгжилт 0,5 хувиар буурсан

байна. Улсын төсвөөс 605,300,000 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 24,200,000 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

3 дугаар улирлын захирамжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж 4 зөвлөмж өгснөөс Төрийн захиргааны удирдлагын хэлтэст өгсөн 3 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Харин Нохой, муурыг бүртгэлжүүлэх гэсэн зөвлөмж хэрэгжээгүй байна. Энэхүү захирамжийн хэрэгжилтийг үр дүнтэй хэрэгжүүлэх тал дээр Мал эмнэлгийн газар анхаарч ажиллах нь зүйтэй.

Хангалтгүй хэрэгжсэн буюу 30 хувьтай хэрэгжиж байгаа 4 заалт байгаа нь Аймгийн Засаг даргын Тамгын газар болон Төрийн цахим үйлчилгээний хэлтэст хамааралтай заалтууд байна.Үүнд:

- ☐ Холбогдох дүрэм журмын дагуу Засаг даргын тамгын газрын бүтэц орон тоо, албан тушаалын тодорхойлолтыг боловсруулан Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлэх ажлын хэсэг байгуулах тухай

- ☐ Засаг даргын дэргэдэх мэдээллийн технологийн “Хурдан” клубийг байгуулах тухай

- ☐ Цахим аймаг хөтөлбөр боловсруулах ажлын хэсэг байгуулах тухай

- ☐ Иргэдийн шинэ жилийн баяр угтсан арга хэмжээ зохион байгуулах ажлын хэсэг томилох тухай гэсэн заалтууд хангалтгүй хэрэгжсэн бөгөөд эдгээр захирамжуудын хэрэгжилтийг эрчимжүүлэхэд хариуцсан харьяа хэлтэс, агентлагууд анхаарах нь зүйтэй.

ТАВ. ЗӨВЛӨМЖ

/Мал эмнэлгийн газарт/

1.Нохой, муурыг бүртгэлжүүлэх тухай захирамжийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, хэрэгжилт удаашралттай байгаа шалтгаан нөхцөлийг тодруулан хэрэгжилтийн үр дүнд хяналт тавих

Бодлогын хэлтсүүд өгсөн зөвлөмжийг холбогдох хэлтэс, агентлагууддаа хүргүүлэн хэрэгжилтэд нь хяналт тавин тайланг 2025 оны 1 дүгээр улирлын захирамжийн хэрэгжилтийн хамт ирүүлэх

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС